МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 13 өдөр Дугаар А/575 Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 12 дахь хэсгийн 12.13 дахь заалт, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15^1 дүгээр зүйлийн $15^1.3$ дахь хэсгийг тус тус тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, Ажлын хэсгийн ажиллах удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү захирамжийн 1 дүгээр зүйлд заасан Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн шаардлага хангасан хуулийн этгээдэд холбогдох хуульд заасны дагуу согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулахыг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Ахлах мэргэжилтэн (Х.Цэнд-Аюуш), хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т даалгасугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

Захирамж-2023

6712011311

Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 13...-ны өдрийн А/575 захирамжийн нэгдүгээр хавсралт

СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, МАГАДЛАН ШАЛГАХ, ДҮГНЭЛТ ГАРГАХ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Гишүүдэд: Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга

Хөвсгөл аймаг дахь Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагааг зохион байгуулах ахлах мэргэжилтэн

Аймгийн Эрүүл мэндийн газрын Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч

Онцгой байдлын газрын Гал түймрийн хяналтын улсын ахлах байцаагч

Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнсний чанар, стандартын улсын байцаагч (Худалдах)

Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнсний чанар, стандартын улсын байцаагч (Үйлчлэх)

Хөвсгөл аймаг дахь Цагдаагийн газрын Холбоо мэдээллийн ахлах инженер, Цагдаагийн ахмад

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Эрх зүйн, хяналт-шинжилгээ, үнэлгээ хууль сахиулах бодлого үйл ажиллагаа зохион байгуулах ахлах мэргэжилтэн

___oOo___

Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А/575 захирамжийн хоёрдугаар хавсралт

СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, МАГАДЛАН ШАЛГАХ, ДҮГНЭЛТ ГАРГАХ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ УДИРДАМЖ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах, түүгээ үйлчлэх тусгай зөвшөөрөл (Цаашид тусгай зөвшөөрөл гэх) олгохтой холбоотой асуудлаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий Ажлын хэсэг (Цаашид ажлын хэсэг гэх)-ээс Зөвшөөрлийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийг баримтлан тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох асуудлаар дүгнэлт гаргах, тусгай зөвшөөрөл олгох эрхий бүхий этгээдэд хүргүүлэхэд энэхүү удирдамжийг баримтална.

Хоёр. Ажлын хэсгийн ажиллах зарчим

2.1 Ажлын хэсэг дараах асуудлыг хэлэлцэж дүгнэлт гаргана;

2.1.1 Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр авах;

2.1.2 Тусгай зөвшөөрлийн хаягийн өөрчлөлт, аж ахуй нэгжийн нэр солих;

2.1.3 Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх;

2.1.4 Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах;

2.1.5 Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох.

2.2 Ажлын хэсэг Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, 15^1 дугаар зүйлийн $15^1.3$ заасны дагуу баримт бичгийн бүрдэл шалгах болон магадлан шалгах ажиллагааг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу 10 өдрийн дотор шийдвэрлэнэ.

2.3 Магадлан шалгах ажиллагаанд төрийн болон мэргэжлийн байгууллагаас дүгнэлт, тодорхойлолт гаргуулах шаардлагатай бол энэ удирдамжийн 2.2-т заасан хугацааг нэг удаа ажлын 5 өдрөөр сунгаж болно.

2.4 Ажлын хэсэг магадлан шалгах хугацааг дуусанаас хойш ажлын 3 өдөрт багтаан хуралдах бөгөөд хурлыг танхимаар болон цахимаар зохион байгуулж, зөвшөөрөл олгох эсэх шийдвэр гаргана.

2.5 Ажлын хэсгийн гишүүдийн олонх оролцсоноор хүчинтэйд тооцно. Хуралд Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга саналын эрхтэй оролцох бөгөөд ажлын хэсгийн хурлын бэлтгэл ажил, зохион байгуулалтыг хариуцан ажиллана.

2.6 Ажлын хэсгийн хурлыг дарга удирдах бөгөөд түүний эзгүйд ажлын хэсгийн нарийн бичгийн дарга удирдана.

Гурав. Ажлын хэсгийн хурлын бэлтгэл ажлыг хангах, магадлан шалгах ажлыг зохион байгуулах:

3.1 Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Эрх зүйн, хяналт-шинжилгээ, үнэлгээ хууль сахиулах бодлого үйл ажиллагаа зохион байгуулах ахлах мэргэжилтэн Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (цаашид "систем" гэх), эсхүл зөвшөөрлийн нэгдсэн сангаар дамжуулан хүсэлт ирүүлсэн хуулийн этгээдийн баримт бичгийн бүрдлийг магадлан шалгасны дараа жагсаалтыг гаргаж, танилцуулгыг бэлтгэж, хуралд танилцуулна.

3.2 Холбогдох байгууллага, хуулийн этгээдээс тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохоор ирүүлсэн саналыг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга хурлаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөнд тусгаж, батлуулна.

3.3 Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нь согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдийн хүсэлтийг магадлан шалгаж, ажлын хэсгийн даргаар хянуулсны дараа ажлын хэсгийн хуралд оруулж танилцуулна.

3.4 Ажлын хэсгийн гишүүд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл хүсэгч энэ журмын 3.2-т заасан жагсаалтад дурдсан хуулийн этгээдийн жагсаалт, мэдээлэлтэй танилцан баримт бичгийн бүрдлийг хянан баталгаажуулж зөвшөөрөл олгох эсэх дүгнэлтэд санал өгнө.

3.5 Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдийн магадлан шалгагдсан мэдээллийг жагсаалтын дагуу хуралд танилцуулж, Ажлын хэсгийн гишүүд тус бүрээс санал авах хуудсыг бөглүүлэн, хурлын тэмдэглэлийн хавсралтад тусгана.

3.6 Ажлын хэсгийн гишүүд нь санал өгөх хуудсанд тусгай зөвшөөрөл олгох саналыг "+" тэмдгээр, татгалзсан болон хугацаат үүрэг даалгавар өгөх үндэслэлийг холбогдох хууль тогтоомж, норм дүрэм, стандартыг тодорхой тусгаж, гарыг үсэг зурж баталгаажуулна.

3.7 Хуралд оролцсон ажлын хэсгийн гишүүд хурлын тэмдэглэлд гарыг үсэг зурж, баталгаажуулах бөгөөд оролцсон гишүүдийн олонхын саналаар дэмжсэн, эсхүл татгалзсан тухай дүгнэлт гаргана. Дүгнэлтэд дарга, гишүүд, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

3.8 Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга хурлын тэмдэглэл, дүгнэлтийг аймгийн Засаг даргад хүргүүлж, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлд заасан хугацаанд шийдвэр гаргуулна.

___oOo__